



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/198/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyо@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23

№

288

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой онцлог асуудлуудыг нэгтгэн харуулав. Үүнд:

Хурлын ажлын албанд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай гэрээний үндсэн дээр хамтран зохион байгуулж хэрэгжүүлсэн. Уг стандартын хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийлгүүлж, баталгаажуулалтын гэрчилгээ авсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд УИХ-д суудалтай намд олгох төрийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс олгох байтал орон нутгийн төсвөөс (нийт 42 төлөөлөгчид 21.0 сая төгрөг) олгосон.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>68,085,539.00</u>	<u>209,249,945.25</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	112,488.25
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	112,488.25
3121	Төгрөг	00.00	112,488.25
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	112,488.25
33	АВЛАГА	00.00	130,121,338.00
335	Бусад авлага	00.00	130,121,338.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	123,970,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	6,151,338.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,085,539.00	79,016,119.00
354	Хангамжийн материал	68,085,539.00	79,016,119.00
35410	Бичиг хэргийн материал	11,802,035.00	11,329,495.00
35420	Аж ахуйн материал	47,129,504.00	53,841,824.00
35440	Түлш, шатах тослох материал	250,000.00	280,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,904,000.00	13,564,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>287,516,274.72</u>	<u>336,342,902.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	287,516,274.72	336,342,902.02
392	Биет хөрөнгө	275,497,941.26	327,338,318.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,900,000.00	49,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,900,000.00	-49,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	285,655,550.00	407,744,050.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,268,518.36	-167,236,384.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231,525,528.00	223,647,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-130,832,638.52	-149,205,786.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,263,400.00	13,643,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,845,379.86	-1,254,059.82
393	Биет бус хөрөнгө	12,018,333.46	9,004,583.50
39301	Програм хангамж	16,045,000.00	16,045,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,026,666.54	-7,040,416.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>355,601,813.72</u>	<u>545,592,847.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	120,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	120,000,000.00
413	Өглөг	00.00	120,000,000.00
4136	Бусад өглөг	00.00	120,000,000.00

41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	120,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>355,601,813.72</u>	<u>425,592,847.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	355,601,813.72	425,592,847.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,892,758.50	137,892,758.50
51101	Өмч: - төрийн	137,892,758.50	137,892,758.50
512	Хуримтлагдсан үр дүн	<u>213,237,925.28</u>	<u>283,228,958.83</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	339,248,775.69	213,237,925.28
51220	Тайлант үеийн үр дүн	-126,010,850.41	69,991,033.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,471,129.94	4,471,129.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>355,601,813.72</u>	<u>545,592,847.27</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,972,645,053.20	4,009,000,009.16
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	112,488.25
120	Нийтлэг татварын бус орлого	-	112,488.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	112,488.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	112,488.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,972,645,053.20	4,008,887,520.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,346,696,453.20	1,504,351,797.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,003,000,000.00	1,090,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	343,696,453.20	413,851,797.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,625,948,600.00	2,504,535,723.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,625,948,600.00	2,504,535,723.71
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,080,166,320.36	3,939,008,975.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,080,166,320.36	3,939,008,975.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,515,318,144.19	2,856,409,135.61

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	833,621,716.09	627,855,100.29
210101	Үндсэн цалин	221,029,922.04	383,888,361.08
210102	Нэмэгдэл	37,558,539.85	80,873,494.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,818,666.86	95,367,626.35
210104	Урамшуулал	522,214,587.34	67,725,618.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,611,392.05	77,273,958.73
210201	Тэтгэврийн даатгал	73,537,127.37	54,532,792.20
210202	Тэтгэмжийн даатгал	7,863,045.20	6,172,121.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,202,151.55	4,737,409.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,536,482.22	1,055,074.82
210205	Эрүүл мэндийн даатгал	15,472,585.71	10,776,560.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,100,000.00	4,590,000.00
210304	Байрны түрээс	5,100,000.00	4,590,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,392,606.69	37,388,649.49
210401	Бичиг хэрэг	33,224,185.00	18,860,750.00
210402	Тээвэр, шатахуун	11,990,000.00	11,370,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,165.69	2,640,099.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,987,256.00	4,517,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	142,196,627.20
210701	Гадаад албан томилолт	-	142,196,627.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	707,776,237.00	925,892,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	702,344,050.00	920,696,628.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,319,520.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,667.00	95,793.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,899,000.00	5,100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	811,816,192.36	1,041,212,378.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	675,237,896.20	923,711,006.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,015,500.00	23,412,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,562,796.16	94,089,172.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,564,848,176.17	1,082,599,840.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	21,000,000.00	21,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	21,000,000.00	21,000,000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	923,977,206.00	931,911,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	99,695,806.00	68,415,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	824,281,400.00	863,496,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	615,405,673.17	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	615,405,673.17	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,465,297.00	129,688,340.00
213504	Хөрөнгийн		129,688,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(107,521,267.16)	69,991,033.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,489,583.25	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,489,583.25	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(18,489,583.25)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(126,010,850.41)	69,991,033.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,972,645,053.20	4,009,000,009.16
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	112,488.25
120	Нийтлэг татварын бус орлого	-	112,488.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	112,488.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	112,488.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,972,645,053.20	4,008,887,520.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,346,696,453.20	1,504,351,797.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,003,000,000.00	1,090,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	343,696,453.20	413,851,797.20
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,625,948,600.00	2,504,535,723.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,625,948,600.00	2,504,535,723.71

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,954,874,853.20</u>	<u>3,865,971,720.91</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,954,874,853.20	3,865,971,720.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,389,808,077.03	2,783,371,880.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	833,621,716.09	627,855,100.29
210101	Үндсэн цалин	221,029,922.04	383,888,361.08
210102	Нэмэгдэл	37,558,539.85	80,873,494.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,818,666.86	95,367,626.35
210104	Урамшуулал	522,214,587.34	67,725,618.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,611,392.05	77,273,958.73
210201	Тэтгэврийн даатгал	73,537,127.37	54,532,792.20
210202	Тэтгэмжийн даатгал	7,863,045.20	6,172,121.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,202,151.55	4,737,409.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,536,482.22	1,055,074.82
210205	Эрүүл мэндийн даатгал	15,472,585.71	10,776,560.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,100,000.00	4,590,000.00
210304	Байрны түрээс	5,100,000.00	4,590,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,612,285.69	35,271,109.49
210401	Бичиг хэрэг	16,856,120.00	16,871,010.00
210402	Тээвэр, шатахуун	11,400,000.00	11,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,165.69	2,640,099.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,165,000.00	4,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	750,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	152,317,965.20
210701	Гадаад албан томилолт	-	152,317,965.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	713,989,537.00	923,562,588.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	708,635,350.00	920,471,795.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,319,520.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,667.00	95,793.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,821,000.00	2,995,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	696,123,146.20	962,501,159.20

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	634,325,396.20	939,088,959.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,797,750.00	23,412,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,565,066,776.17	1,082,599,840.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	21,000,000.00	21,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	21,000,000.00	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	924,195,806.00	931,911,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	99,695,806.00	68,415,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	824,500,000.00	863,496,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	619,870,970.17	129,688,340.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	615,405,673.17	129,688,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,770,200.00	143,028,288.25
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,770,200.00	142,915,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,770,200.00	142,915,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,770,200.00	142,915,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,770,200.00	142,915,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,770,200.00)	(142,915,800.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	112,488.25
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	112,488.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	339,248,775.69	481,612,664.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	339,248,775.69	481,612,664.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-126,010,850.41	-126,010,850.41
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	213,237,925.28	355,601,813.72
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	213,237,925.28	355,601,813.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	213,237,925.28	355,601,813.72
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	69,991,033.55	69,991,033.55
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,892,758.50	4,471,129.94	283,228,958.83	425,592,847.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,921,515,500.00	2,504,535,723.71	416,979,776.29	85.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,921,515,500.00	2,504,535,723.71	416,979,776.29	85.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785,515,500.00	2,372,124,223.71	413,391,276.29	85.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,539,300.00	627,855,100.29	152,684,199.71	80.4
210101	Үндсэн цалин	369,739,500.00	383,888,361.08	-14,148,861.08	103.8
210102	Нэмэгдэл	129,622,200.00	80,873,494.74	48,748,705.26	62.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	129,126,700.00	95,367,626.35	33,759,073.65	73.9
210104	Урамшуулал	152,050,900.00	67,725,618.12	84,325,281.88	44.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,149,200.00	77,273,958.73	20,875,241.27	78.7
210201	Тэтгэврийн даатгал	66,927,600.00	54,532,792.20	12,394,807.80	81.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,805,400.00	6,172,121.26	1,633,278.74	79.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,244,300.00	4,737,409.66	1,506,890.34	75.9

210204	Ажилгүйдлийн даатгал	1,561,100.00	1,055,074.82	506,025.18	67.6
210205	Эрүүл мэндийн даатгал	15,610,800.00	10,776,560.79	4,834,239.21	69.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,590,000.00	4,590,000.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	4,590,000.00	4,590,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,150,100.00	35,271,109.49	878,990.51	97.6
210401	Бичиг хэрэг	17,750,000.00	16,871,010.00	878,990.00	95.0
210402	Тээвэр, шатахуун	11,400,000.00	11,400,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,100.00	2,640,099.49	0.51	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,360,000.00	4,360,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,750,000.00	18,675,000.00	75,000.00	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,750,000.00	18,675,000.00	75,000.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	189,884,900.00	152,317,965.20	37,566,934.80	80.2
210701	Гадаад албан томилолт	189,884,900.00	152,317,965.20	37,566,934.80	80.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	913,817,000.00	875,953,128.00	37,863,872.00	95.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	910,000,000.00	872,862,335.00	37,137,665.00	95.9
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	00.00	700,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	95,793.00	4,207.00	95.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00	22,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,995,000.00	2,995,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	743635000.00	580187962.00	163,447,038.00	78.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	693,635,000.00	556,775,762.00	136,859,238.00	80.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000,000.00	23,412,200.00	26,587,800.00	46.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136000000.00	132411500.00	3,588,500.00	97.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	21,500,000.00	21,000,000.00	500,000.00	97.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	21,500,000.00	21,000,000.00	500,000.00	97.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,500,000.00	111,411,500.00	3,088,500.00	97.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	71,500,000.00	68,415,000.00	3,085,000.00	95.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,000,000.00	42,996,500.00	3,500.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,921,515,500.00	2,504,648,211.96	416,867,288.04	85.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,921,515,500.00	2,504,535,723.71	416,979,776.29	85.7
132001	Орон нутгийн төсвөөс	2,921,515,500.00	2,504,535,723.71	416,979,776.29	85.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	112,488.25	-112,488.25	0.0

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	112,488.25	-112,488.25	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	112,488.25	-112,488.25	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	112	112	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	6	6	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	62	62	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	43	43	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112	112	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16	16	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	51	51	0.00	100.0
650010	Гэрээт ажилтан	43	43	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,504,351,797.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,504,351,797.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,163,457.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,697,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,697,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	403466197.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,466,197.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	820,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	820,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	820,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,688,340.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	129,688,340.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1504351797.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,504,351,797.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,090,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	413,851,797.20

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 112.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Арилжааны банкны дансны үлдэгдэл 112.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12,288.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 864.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,424.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Албан хэрэгцээнд дуудлагын авто машин ашиглахдаа тогтоосон нормоос илүү 864.3 мянган төгрөг зарцуулсан. Энэ нь Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны 204 дүгээр тогтоолын 8 " энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрэхгүйгээр ашиглах байхаар тогтоосугай" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын холбоотой асуудал

Илрүүлэлт: Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтан (*Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга*) дуудлагын авто машин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулж 9,170.4 мянган төгрөгийн зардал гарган төсвийг үр ашиггүй зарцуулсан нь төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хэрэгцээнд дуудлагаар ашиглаж байгаа автомашиныг илүү цагаар ажиллуулахгүй байж төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалин хөлсийг 726.8 мянган төгрөгөөр (*илүү 60.0 мянган төгрөг, дутуу 666.8 мянган төгрөг*) зөрүүтэй тайлагнасан нь алба хаагчдын цалин, түүнээс суутгуулсан нийгмийн даатгалын шимтгэл алдаатай

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үнэн зөв тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт: Жилийн эцсээр ажилчдын цалингаас суутгасан ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог алдаатай хийснээс суутгасан болон татварын тайлангийн ногдуулсан татвар 1,527.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь татварын хөнгөлөлтийг буруу тооцон тайлагнах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан татвар ногдуулах жилийн орлого болон татварын хөнгөлөлтийн хэмжээг албан хаагч нэг бүрээр үнэн зөв тооцож, тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд гарсан чадавхжуулах зардлыг холбогдох захирамж, мөнгөн хөрөнгийн журнал, гэрээ, хэлцэл, анхан шатны баримт руу хөөн шалгахад УИХ-д суудалтай намд олгох төрийн санхүүгийн дэмжлэгт орон нутгийн төсвөөс нийт 42 төлөөлөгчийн 21,000.0 мянган төгрөгийг олгосон. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2."Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УИХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгохгүй байх зөвлөмж өглөө.

Иргэдийн хурлын 11 төлөөлөгчдийн гадаад томилолтын зардалд 60,938.0 мянган төгрөгийг зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "энгийн хялбар, чанга хатуу байх"; 4.1.3 "үр ашигтай байх"; 12 дугаар зүйлийн 12.1"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно."; 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын 3.2.6. "гадаад улсын болон дотоодын туршлага судлах сургалт";заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын эзэмшил, данс бүртгэлтэй "HYUNDAI AZERA" маркийн суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй байна. Энэ нь Стандарт,

хэмжилзүйн газрын даргын баталсан “MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг : Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалт “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “HYUNDAI AZERA” маркийн авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр сольж ашиглах хүсэлтийг холбогдох байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Арилжааны банкны дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан	1	112.5	1	112.5			1	112.5				
Дүн	1	112.5	1	112.5			1	112.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дуудлагын авто машин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулж төсвийг үрэлгэн зарцуулсан	1	9,170.4					1	9,170.4				
Албан хэрэгцээнд дуудлагын авто машин ашиглахдаа тогтоосон норм хэтрүүлсэн	1	864.3	1	864.3								
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд	1	726.8					1	726.8				

цалин хөлсийг зөрүүтэй тайлагнасан										
Цалингаас суутгасан болон татварын тайлангийн ногдуулсан татвар зөрүүтэй	1	1,527.4				1	1,527.4			
Дүн	4	12,288.9	1	864.3		3	11,424.6			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа "HYUNDAI AZERA" маркийн суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй	1						1	
Иргэдийн хурлын төлөөлөгчдийн гадаад томилолтын зардал гаргасан	1	60,938.0			1	60,938.0		
УИХ-д суудалтай намд орон нутгийн төсвөөс дэмжлэг олгосон	1	21,000.0					1	21,000.0
Дүн	3	81,938.0			1	60,938.0	2	21,000.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			